

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМНААС 2009 ОНЫ 07 ДУГААР САРД ХИЙСЭН ГОЛ АЖИЛ

Нэг. Бодлого төлөвлөлтийн асуудлаар:

1. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн асуудал:

- “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Засгийн газрын 2009.07.08-ны хуралдаанаар хэлэлцүүлж 208 дугаар тогтоолоор батлуулав.
- “Мал өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулан Засгийн газрын 2009 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж 221 дүгээр тогтоолоор батлуулав.

2. Судалж, боловсруулсан асуудлын талаар:

- “Мал өвөлжилтийн бэлтгэл хангах тухай” ХХААХҮ-ийн Сайдын 2009 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 01 тоот албан даалгавар гаргаж аймаг, орон нутагт хүргүүлээ.
- Дотоодын ноос, ноолуур, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэн, зөгийн балыг худалдан авсан этгээдийн үнэд НӨАТ шингэсэн гэж үзэж худалдан авсан үнээс хасалт хийх асуудлыг зохицуулахаар “НӨАТ-ын тухай хуульд нэмэлт оруулах тухай” хуулийн төслийг Сангийн яамтай хамтран боловсруулж яамдаас санал авав.
- “Ноос” хөтөлбөрийг шинэчлэн анхны хувилбарыг боловсрууллаа.
- ХХААХҮ-ийн салбарын иновацийн дэд хөтөлбөрийг шинээр боловсруулах ажлын хэсэг ажиллаж хөтөлбөрийн анхны хувилбарыг боловсруулав.
- Мал эмнэлэг, үржлийн анхан шатны нэгжийг дэмжих” хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийг Сайдын 155 дугаар тушаалаар батлуулж, ажлын хэсгийг хуралдуулж, ажлын төлөвлөгөөг гарган ажиллаж байна.
- “Чацаргана” хөтөлбөрийн төсөл боловсруулах ажлыг эхлүүлэв.
- “Бараа, түүхий эдийн биржийн тухай” хуулийн төсөл, үзэл баримтлалыг боловсруулан, холбогдох яамдаас санал авахаар хүргүүлэв. Түүнчлэн Бараа, түүхий эдийн биржийн “Арилжааны журам” болон “Дотоод дүрэм”-ийг боловсруулж байна.
- “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн үзэл баримтлалын төслийг боловсруулав.
- “Хоршооны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.
- Биржийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг ХЗДХЯ-аар батлуулж, хуулийн төсөлд яамд, холбогдох газруудаас санал авч байна.
- Арьс ширний үйлдвэрийн салбарын стандартыг дахин хянаж, үнэлгээ хийж, шинэчлэх, шинээр боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.
- “Малын үржлийн ажил үйлчилгээг сайжруулах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулан яамдаас санал авч байна.
- “Эрчимжсэн МАА-н хөгжлийг дэмжих” хөтөлбөрийн хүрээнд гадаад дотоодын зах зээлээс сүү, махны өндөр ашиг шимтэй 250 толгой үржлийн өсвөр үхэр худалдан авах тендерт оролцогчдын ирүүлсэн тендерийн баримт бичигт үнэлгээ хийж байна.
- “Ахуйн үйлчилгээний салбарыг дэмжих хөтөлбөр”-ийн Үндэсний зөвлөлд ажиллах бүрэлдэхүүнийг байгуулахаар холбогдох яамдаас санал авч Сайдын тушаалын төслийг боловсруулан, танилцуулж байна.
 - Хүнсний нэмэлтийг улсын бүртгэлд бүртгэх, хяналт тавих журмын төслийг холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулав.
- Дотооддоо импортыг орлох тоног төхөөрөмж үйлдвэрлэдэг аж ахуйн нэгжийн судалгааг гаргав. Тухайлбал энэ чиглэлээр 60 гаруй аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулдаг бөгөөд тодорхой захиалгын дагуу цөөхөн тоотой үйлдвэрлэдэг бөгөөд Улсын хэмжээнд аваад үзвэл Улаанбаатарт 167, Орхон аймагт 4, Дархан-Уул аймагт 3 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж 2008 оны төсөвт 655.016.600 төгрөгийн орлого оруулсан байна.

Хоёр. Бодлогын хэрэгжилтийг зохицуулах асуудлаар:

- “Мал өвөлжилтийн бэлтгэл хангах тухай” ХХААХҮ-ийн Сайдын 2009 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 01 тоот албан даалгавар гаргаж аймаг, орон нутагт хүргүүлсэн.
- Жижиг дунд үйлдвэрийг дэмжих зээлийн явц, үр дүнгийн талаар хэвлэлийн бага хурлыг 7 дугаар сарын 22-ны өдөр Засгийн газрын ордонд зохион байгуулав. Зээл олгох дэд сангийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний албан даалгаврыг аймгуудын Засаг дарга нарт хүргүүлэв. Одоогоор орон нутагт 10,5 тэрбум, Улаанбаатар хотод 7 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг шилжүүлээд байна.
- Монгол Улсын Тэргүүн Шадар сайд, Шадар сайдын багцад орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор тусгагдсан хөрөнгийг Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд төвлөрүүлж, УИХ-ын гишүүдтэй хамтран ажиллах гэрээ байгуулж байна.
- Сүү II төслийн хүрээнд Баянхонгор, Өвөрхангай, Хөвсгөл, Орхон, Архангай аймгуудад ашиглалтад орж байгаа сүүний үйлдвэрүүдийн нээлтийн ажиллагааг зохион байгуулав.
- Таван аймгийн 400 цэгт газрын доорхи усны нөөцийн геофизикийн хайгуулын ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулж гэрээ байгуулан, урьдчилгаа санхүүжилт 120 сая төгрөгийг шилжүүлэх ажлыг зохион байгуулж байна.
- ХХААХҮ-ийн Сайдын 2009 оны нөөц хөрөнгөөр 14 аймаг, нийслэлд 32 шинэ худгийг 320 сая төгрөгөөр барьж байгуулах тухай Сайдын 160 тоот тушаалын дагуу тендерт шалгарсан компаниудтай нэмэлт гэрээ байгуулсан.
- Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгээс хийсэн 2009 оны хаврын үлийн цагаан оготны тархалтын хөнөөлийн тодотгох судалгааны дүнг үндэслэн бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж буй үлийн цагаан оготной тэмцэх ажлыг энгийн механик аргаар энэ оны 5, 6 дугаар сард нийт 9 аймгийн 56 сумын 250 мянган га бэлчээрийн талбайд зохион байгуулж дуусгаад байна. Энэ арга хэмжээнд нийт 400 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж дээрх аймгуудын ХХААЖДҮГ-тай байгуулсан гэрээг үндэслэн шаардагдах санхүүжилтийг бүрэн шилжүүлсэн байна.
- Уриншийн ажлын явц, чанарын байдал, техникийн байдлыг газар дээр нь үзэж шийдвэрлэхээр 3 ажлын хэсэг Төв, Сэлэнгэ, Булган, Хөвсгөл аймгуудын тариалан бүхий сумдад ажиллав Өнөөдрийн байдлаар уринш боловсруулалт 65 хувьтай явж байна. Уриншийн зориулалтаар иргэн, аж ахуйн нэгжид 4300 тн дизелийн түлш, үр тарианы хог ургамал устгах гербицид бутилийн эфир 65200 литр, алмазис 175 кг, химийн уриншийн хор Раунд ап 138000 литр, төмс, хүнсний ногооны гербицид грамоксон 753, гзегард 478, децис 301 литрийг тус тус иргэн, аж ахуйн нэгжүүдэд олгоод байна.
- Үр тариа цэвэрлэх машин, будаа ачигч машины нийлүүлэгч, услалтын системийн тендерт шалгарсан аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулсан ба элеватор нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийн нээлт хийгдэж байна. Үр тарианы комбайн худалдан авах тендерийн үнэлгээний хорооны шийдвэр гарч хяналтын хэсгээр хянуулж Сангийн яаманд зөвшөөрөл авахаар хүргүүлээд байна.
- Согтууруулах ундааны техникийн зохицуулалтын хэрэгжилтийг хангуулах асуудлаар ЭМЯ, МХЕГ, СХҮТ болон холбогдох бусад газруудтай уулзалт зохион байгуулав.
- Хүүхдийн дүрэмт хувцасны стандартуудыг хянах, шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг байгуулахаар холбогдох байгууллагуудаас оролцох хүмүүсийн нэрсийг авч байна.
- “Барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоо” ТББ-тай хамтын ажиллагааны чиглэлийг тогтож, хамтран ажиллах гэрээний төсөл боловсруулсан. ЖДҮ хөгжүүлэх барилгын салбарт орон нутгийн түүхий эдийн нөөцийн мэдээ судалгааг гаргаад байна.
- Мянганы сорилын сангийн төсөлд Мал үржлийн үйлчилгээний нэгжийн чадавхийг сайжруулах чиглэлээр тодорхой асуудлыг боловсруулж өгөв. Мал эмнэлгийн бүртгэл мэдээллийн системийг сайжруулах чиглэлээр шаардлагатай мэдээлэл судалгааг гарган өгч, дээрх асуудлуудыг Мянганы сорилын сангийн төслийн төсөлд тусгуулсан болно.
- Жимс жимсгэний аж ахуйд дэмжлэг үзүүлэх “Төсөл шалгаруулж, дэмжлэг үзүүлэх тухай” ХХААХҮ Яамны Төрийн нарийн бичгийн даргын 2009 оны 131 дүгээр тушаалын дагуу төсөл хэрэгжүүлэхээр 72 аж ахуйн нэгж, иргэнтэй гэрээ хийн 826.5 сая төгрөгийн санхүүжилт олгоод байна.
- ХХААХҮ-ийн сайдын 2009 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 138 тоот тушаалаар Сангийн яам, Эрдэс баялаг, эрчим хүчний яамтай хийсэн хамтарсан гэрээний дагуу, “НИК”ХК-тай гэрээ байгуулж тариалан эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдийн 2009 оны уринш боловсруулалтад шаардагдах түлшний гэрээг 235 аж ахуйн нэгж, иргэдтэй хийж 1705 тонн түлшийг “НИК” ХК-ийн аймаг орон нутаг дахь шатахуун түгээх станцаас олгоод байна. Мөн ХХААХҮ-ийн сайдын 2009 оны 07 дугаар сарын 14-ны өдрийн 171 тоот тушаалаар Улсын нөөцөөс гаргасан дизель

түлшний үлдэгдэл 1400 тонноос 333 аж ахуйн нэгжид 1035 тонн түлшийг олгов. Ингэснээр газар тариалан эрхлэгч аж ахуйн нэгж иргэдийн уринш хийх нөхцлийг бүрдүүлж байна.

- ОХУ-аас зээлээр орж ирсэн үрийн будааны тоо хэмжээг эцэслэн нийлүүлэгч компанитай тооцоо нийлж, нийт 2.301.060 ам. долларын үнийн дүн бүхий 5752,65 тн үрийн буудай, 6.584,266 ам. долларын үнийн дүн бүхий техник хүлээн аваад байна.
- ОХУ-аас зээлээр орж ирж буй ХАА-н техник хэрэгслүүдийг ХХААХҮ-ийн сайдын тушаалаар МТЗ-82.1 дугуйт трактор 34 аж ахуйн нэгж иргэнд 36 ширхэг МТЗ-1221.1 дугуйт трактор 20 ширхэгийг 15 аж ахуйн нэгжид, МТЗ-1221.1 давхар дугуйт тракторыш 31 ширхэгийг 23 аж ахуйн нэгжид, ВТЗ-2032А маркын жижиг оврын тракторыг 2 аж ахуйн нэгжид 2 ширхэгийг холбогдох журмын олгоод байна.
- Мөн ХХААХҮ-ийн сайдын 2009 оны 06-р сарын 15-ны 142 тушаалаар “Техник үйлчилгээний дундын төв”-ийг 7 аймгийн 10 суманд байгуулж 30 морины хүчтэй дугуйт трактор, төмсний иж бүрдэл 9 ширхэг, шүдэт борной 32 ширхэг, ПЛН-3.35 анжис 8 ширхэг, Лидер-4 сийрүүлүүр 2 ширхэг, үр тарианы комбайн 2 ширхэг, МТЗ-1221.1 дугуйт трактор 2 ширхэг, МТЗ-82.1 дугуйт трактор 8 ширхэгийг олгоод байна.
- Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улааны аймаг дундын отрын бэлчээрийн талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 165 дугаар тогтоолын биелэлтийг ХХААХҮ-ийн Дэд сайд Ж.Саулегаар ахлуулсан ажлын хэсэг явж газар дээр нь танилцаж, гурвалсан гэрээ байгуулж, гэрээнд бэлчээрийн харуулын хариуцах газар нутгийн нэр, уг газарт байршилтай өвөлжөө, худаг болон бусад хөрөнгө хариуцах харилцааны тогтолцоо, хөдөлмөр хамгаалал, тухайн сумдын Засаг дарга, тосгоны захирагч нарын үүрэг хариуцлага зэргийг нарийвчлан тусган, Хэнтий аймгийн Цэнхэрмандал-1, Жаргалтхаан-1, Дэлгэрхаан-2, Хэрлэнбаян-Улаан отрын бүс нутагт-5 нийт 9 харуул томилон ажиллуулаад байна. Мөн отрын бүс нутагт 50 га талбайн таримал тэжээл тариалах услалтын системийг хүлээж авах ажлын хэсгийг бүрдүүлж уг услалтын системийг хүлээн авч хэвийн ажиллагаанд оруулаад байна.
- Зохиомол хээлтүүлгийн явуулын үйлчилгээ 44-ийг ажиллуулж, гүн хөлдөөсөн үрээр сүү, махны чиглэлийн үнээнд зохиомол хээлтүүлэг хийж байна. Үхрийн зохиомол хээлтүүлгийн ажилд мэргэжлийн зөвлөлгөө өгч, эрчимжүүлэх зорилгоор Мал эмнэлэг, үржлийн газартай хамтран ажлын хэсэг гаргаж, Төв, Сэлэнгэ, Булган аймаг, Улаанбаатар хотын зарим эрчимжсэн аж ахуйнд ажиллууллаа.
- Сүүний үхрийн 205 аж ахуйн 2735 үнээнд ашиг шимийн бүртгэл хийж, гарьвал, ашиг шимийн мэдээллийн санг баяжуулав. Ашиг шимийн бүртгэлд хамрагдсан нийт үнээний хоногийн дундаж саам 7.6 кг, сүүний тослог 3.47%, уургийн агууламж 3.68% байна. Сүүний гарц болон бусад үзүүлэлтүүдийг агуулсан мэдээллийг эрчимжсэн аж ахуй эрхлэгчдэд хүргүүлээд байна. Сүүний үхрийн гарьвал, ашиг шимийн мэдээллийн санд 2008 оны 07 дугаар сараас 2009 оны 07 дугаар сар хүртэлх хугацаанд оруулсан мэдээлэлд тулгуурлан үнээний үржлийн үнэт чанарыг тодорхойлов. Саамын 150 хоногийн сүүн ашиг шимээр үнэлэгдсэн 448 үнээний дундаж саам 1505 кг, 180 хоногийн сүүн ашиг шимээ үнэлэгдсэн 143 үнээний дундаж саам 2487 кг байна. “Мон таримал” компанийн 14189 дугаартай Хар тарлан үүлдрийн үнээний хоногийн саамын хэмжээ 31.7 кг байна.

4. Гурав. Гадаад хамтын ажиллагаа болон дотоод ажлын талаар

- Монгол Улсын Ерөнхий сайд С.Баярын Япон Улсад хийх албан ёсны айлчлалын бүрэлдэхүүнд хамт явах сайд Т.Бадамжунай болон холбогдох газрын дарга нар дагалдан явлаа.
- Японы Засгийн газраас Хүнсний тусламжийн КР-1 төслийн хүрээнд 20,000 тонн цагаан будаа авах хүсэлтийг Япон Улсаас Монгол Улсад суугаа ЭСЯ-тай зөвшилцөн Сангийн яаманд уламжлав.
- Бүгд Найрамдах Солонгос Улсын “КОЙКА” байгууллагын санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Халх голын бүс нутагт хөдөө аж ахуйг сэргээн хөгжүүлэх мастер төлөвлөгөө боловсруулах төсөл”-ийн эцсийн шатны тайлангийн арга хэмжээг зохион байгуулав.
- Энэтхэгийн Засгийн газраас 2009 онд Монгол улсад үзүүлэх тусламжийн улаан буудай, цагаан будааны стандарт үзүүлэлтийг гаргаж Энэтхэгийн ЭСЯ болон ГХЯ-д тус тус хүргүүлэв.
- ХХААХҮЯ, БНХАУ-д суугаа Монгол Улсын ЭСЯ хооронд 2009 онд хамтран ажиллах ажлын төлөвлөгөөний төслийг боловсруулан Бээжин дэхь Монгол Улсын ЭСЯ-д хүргүүлэн санал авч байна.
- БНСВУ-аас буцалтгүй тусламжаар авах 1000 тн цагаан будааг хүлээн авах арга хэмжээг Сангийн яамтай хамтран зохион байгуулах чиглэлээр ажиллаж байна.

- Улсын Их баяр наадмаар НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын Бээжин дэхь суурин төлөөлөгч хатагтай Виктория Секитолокогийн Монгол Улсад хийх айлчлалыг зохион байгуулав.
- Монгол, Чехийн Засгийн газар хоорондын хамтарсан комиссын ээлжит 3 дугаар хуралдаан 2009 оны 9 дүгээр сарын 8-10-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо хуралдахтай холбогдуулан хамтарсан 2 дугаар хуралдаанаар байгуулсан Протоколыг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлт болон явцын талаарх мэдээлэл, 3 дугаар хуралдаанаар хэлэлцэх асуудалд тусгах санал боловсруулан хүргүүлэв.
- НҮБ-ын ХХААБ-ын төлөөлөгчийн газар Монгол Улсад байгуулагдан, энэ оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн байранд албан ёсоор үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Энэ талаарх мэдэгдэлийг Гадаад харилцааны яам болон Сангийн яаманд тус тус хүргүүллээ.
- “Хүнсний баталгаат байдал” Үндэсний хөтөлбөрийн хүрээнд уг хөтөлбөрийг танилцуулах, санхүүжилэх эх үүсвэр бий болгох зорилгоор энэ оны 10 дугаар сард зохион байгуулахаар төлөвлөж буй “Хандивлагчдын дээд хэмжээний зөвлөлдөх уулзалт”-ыг зохион байгуулах Ажлын хэсгийн хурлыг зохион байгуулсан. Уг хурлын үеэр Хандивлагчдын дээд хэмжээний уулзалтыг 2009 оны 10 дугаар сарын 08, 09-ний өдрүүдэд зохион байгуулахаар тогтон, уулзалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсрууллаа. Түүнчлэн “Хүнсний баталгаат байдал” Үндэсний хөтөлбөрийн товч танилцуулгын орчуулгыг хянуулахаар НҮБ-ын ХХААБ-т хүргүүлэн, хэвлүүлэх чиглэлээр ажиллаж байна.
- АНУ-ын ХАА-н департаментийн Бээжин дахь суурин төлөөлөгч ноён Эрик Трактенберг болон бусад холбогдох албаны хүмүүс дэд сайд Х.Золжаргалтай уулзах уулзалтыг зохион байгуулав. Энэ уулзалтаар Монгол улс 2011 болон 2012 онуудад АНУ-ын хөгжлийн албан ёсны тусламж болох Хүнс-хөгжлийн төлөө хөтөлбөрийг дахин хэрэгжүүлж эхлэх асуудлаар ярилцаж 2 тал зарчмын хувьд тохиролцсон ач холбогдол бүхий уулзалт боллоо.
- ОХУ-ын ХААЯ, мал эмнэлгийн алба, ургамал хорио цээр хяналтийн газрын мэргэжилтнүүд Монгол Улсад ирж монгол малыг эрүүлжүүлэх, ОХУ-д нийлүүлэх мал, мах махан бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор ажиллах томилолтыг зохион байгуулав. Үүний үр дүнд хоёр тал “Монгол Улсаас ОХУ-д мал, мах, махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, Монгол орны мал сүргийг эрүүлжүүлэх, гоц халдварт өвчнөөс сэргийлэх талаар хоёр орны хамтын ажиллагааг хөгжүүлэх арга хэмжээний хөтөлбөр” –ийг хамтран боловсруулж, хэрэгжүүлэхэд шаардлагатай байгаа 370 сая рублийн санхүүгийн асуудлыг ОХУ-ын Ерөнхийлөгч Д.А.Медведевийн 2009 оны 8 сард Монгол Улсад хийх айлчлалаар шийдвэрлүүлэх саналыг ГХЯ-нд хүргүүлээд байна.
- Дэлхийн зөн” ОУБ-тай 2010 онд хамтран ажиллах чиглэлээр санал боловсруулан, “Дэлхийн зөн” ОУБ-ын захиралтай уулзалт хийлээ.
- Бизнес инкубатор төвүүдийн нэгдсэн холбооны удирдах зөвлөлтэй уулзан хамтын ажиллагааны чиглэлийг тогтоон Сургалт, гадаадын мэргэжилтэнг ажиллуулах чиглэлээр хамтын ажиллагааг эхлүүлэв.
- Японы “ЖАЙКА” байгууллагын шугамаар “МАА, газар тариалан хосолсон загвар аж ахуйн хөгжлийг дэмжих төсөл”-ийн эцсийн шатны үр дүнгийн нэг болох “Хосолсон загвар аж ахуйн стратегийн төлөвлөгөө”-г боловсруулах ажлын хэсгийг байгуулж, ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2009 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн 197 тоот тушаалаар баталгаажуулав.
- Атрын гурав дах аян тариалангийн хөгжлийн үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2009 оны 07 дугаар сарын 20-ний өдрөөс 30-ны өдрүүдэд Оросын Холбооны Улсын Эрхүү хотын Хөдөө аж ахуйн академитэй хамтран газар тариалан эрхэлж буй аж ахуйн нэгжийн удирдах ажилтан, менежерүүдийн түвшинд зохион байгуулах сургалтад монголын агрономчидийг хамруулан 20 хүнийг оролцуулж, сургалтыг зохион байгуулаад байна.
- Тяньжинь хотын хөгжил Шинэтгэлийн хорооны дэд дарга Гуань Линиэн дэд сайд Х.Золжаргалтай уулзах уулзалтыг зохион байгуулж Хятадын Tianjing хотын Бинхай шинэ дүүрэгт баригдаж буй Дунжяны эдийн засаг, худалдааны чөлөөт бүсийг байгуулах ажлын хэсгийн хуралдаанд оролцож цаашид уг асуудлаар хамтран ажиллахаар тохиролцов.
- АНУ-ын сайн дурын байгууллага болох Мэрси Корын төлөөлөгч ноён Доминик Грахамтай уулзалт зохион байгуулан Хүнсний баталгаат байдал хөтөлбөрийн хүрээнд 2 тал санамж бичиг байгуулан хамтран ажиллах талаар ярилцлаа.

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ